

Тус гаалийн газар 2022 онд 59539 чингэлэг бүхий бараа тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авч, бүрдүүлэлт хийгдэж суларсан 511 хоосон чингэлгийг автозамаар, 53848 чингэлгийг төмөр замаар хилийн гаалийн хяналтад илгээсэн.

Түүнчлэн 774 чингэлгийг экспортын ачаанд зориулан гаалийн хяналтын бүс сольж, 2127 чингэлгийг “чингэлэг хяналт”-ын програмаас хасан, 1414 мэдүүлгээр 2139 хоосон чингэлэгт 400 горимоор гаалийн бүрдүүлэлт хийж 2254.1 сая төгрөгийн татвар, 25.6 сая төгрөгийн хураамжийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Гаалийн байгууллагын зүгээс хяналтын давхардлыг арилгах, хууль ёсны гадаад худалдааг дэмжих, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр эрчимтэй ажиллаж байна.

Гаалийн байгууллага нь гадаад худалдааг дэмжих зорилгоор хууль сахилтын түвшин өндөр, гаалийн байгууллагад бараагаа үнэн зөв мэдүүлдэг иргэн аж ахуйн нэгжийг гаалийн бичиг баримтын болон биет шалгалтаас чөлөөлөх чиглэлээр судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг хийж байна.

Бидний хэрэгжүүлж буй гаалийн байгууллагын шинэчлэлийг дэмжиж Та бүхнийг цаашид идэвхитэй хамтран ажиллана гэдэгт найдаж байна.

Улаанбаатар хот дахь гаалийн газар

Хаяг:

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг

1-р хороо Тээвэрчдийн гудамж

Холбоо барих утас-21252181

Цахим шуудангийн хаяг:

ubgg@customs.gov.mn



УЛААНБААТАР ХОТ ДАХЬ ГААЛИЙН ГАЗАР

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБА



2023 ОН

Гаалийн хяналт шалгалтын зохион байгуулалтыг дараах чиглэлээр хэрэгжүүлж байна

1. ачааны манифестийн хяналт
2. гаалийн хяналтын бүсийн журмын хэрэгжилт
3. гаалийн баталгаат бүсийн журмын хэрэгжилт
4. тээврийн хэрэгслийн хяналт
5. зорчигчийн бараанд тавих хяналт
6. дипломат ачааны бүртгэл, хяналт
7. гаалийн хяналтын тоног төхөөрөмжийн ашиглалт
8. гаалийн зөрчил илрүүлэлт


Гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааг доорхи чиглэлээр зохион байгуулж байна.



Нийт бараа эргэлтийг сүүлийн 2-н жилээр харуулбал


№	Үзүүлэлт	2021 он	2022 он	Өссөн /+/ Буурсан /-/
1	Гадаад худалдааны бараа эргэлт импорт /сая ам.доллар/	3,701.3	4,650.6	25.6
2	Гадаад худалдааны бараа эргэлт экспорт /сая ам.доллар/	684.3	745.2	8.9
3	Гадаад худалдааны бараа эргэлт импорт, экспортын нийт дүн /сая ам.дол/	4,385.6	5,395.8	23.0

Импортын хяналт шалгалтаар




Импортын барааны статистик дүн

/сая ам.доллар/



Экспортын хяналт шалгалтаар



Гаалийн хяналт шалгалтанд сүүлийн үеийн тоног төхөөрөмж аишлаж байна

